

Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгийн радио хувиргал дахь хүүрнэл ба хөгжим, дуу чимээний утгын шинжилгээ

Санзайжавын Басбиш 

Соёл урлагийн их сургууль, Улаанбаатар, Монгол Улс
 basbish81@gmail.com

Ганбаатарын Нандинбилиг 

Монгол улсын их сургууль, Улаанбаатар, Монгол Улс

Хураангуй: Монголын радио анх үүссэн цагаасаа уран зохиолын төрөл зүйлд тулгуурлан радио уран сайхны бүтээлүүдийг туурвисаар ирсэн нь утга зохиолын бүтээлийг сонсголын урлагт нийцүүлэн дахин бүтээх, дамжуулах өвөрмөц урлагийн хэлбэрийг бий болгосон. Энэхүү судалгаанд Монголын Үндэсний олон нийтийн радиогийн “Алтан сан хөмрөг”-т хадгалагдаж буй их зохиолч Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгээр хийсэн хөгжимт радио зохиомжийг сонгон авч, хүүрнэн өгүүлэгчийн байр суурь, хөгжим, дуу чимээний семиотик хэрэглээ хэрхэн утга агуулгыг баяжуулж, сонсогчийн сэтгэл зүйд нөлөөлж буйг судлахыг зорив. Судалгаанд адаптаци, нарратологи, медиа онол, семиотик шинжилгээний арга зүйг ашиглаж, эх зохиол болон радио хувиргалын өгүүлэмж, хүүрнэл, уран сайхны хэрэглүүрийн ялгааг харьцуулж, шинжилгээ хийсэн болно. Судалгааны үр дүнд радио зохиомжид хөгжим, дуу чимээ, хүүрнэл гурвын зохистой хослол нь эх зохиолын утга агуулгыг гүнзгийрүүлж, үйл явдлын уур амьсгал, дүрийн сэтгэл хөдлөлийг оновчтой илэрхийлж, сонсогчдын төсөөлөл, сэтгэл хөдлөлийг өдөөж байгааг ажиглав. Уран зохиолын радио хувиргал нь эх зохиолыг дамжуулахаас гадна түүнийг дахин бүтээж, сонсогчдод шинэ мэдрэмж, уран сайхны илэрхийллийн шинэ хэлбэрийг бүрэлдүүлж байна.

Түлхүүр үгс: радио зохиомж, өгүүлэгч, хөгжим, семиотик

An analysis of narrative, music, and sound in the radio adaptation of D.Natsagdorj's Story *Khuduu Taliin Üzesgelen*

Basbish Sanzaijav ✉ 

Mongolian National University of Arts and Culture, Ulaanbaatar, Mongolia
✉ basbish81@gmail.com

Nandinbilig Ganbaatar 

National University of Mongolia, Ulaanbaatar, Mongolia

Abstract: Since its inception, Mongolian radio has created radio art productions based on various literary genres, establishing a unique artistic form that reinterprets and transmits literary works in aural form. This study focuses on the musical radio adaptation of the renowned writer D.Natsagdorj's short story "*Khuduu Taliin Üzesgelen*" preserved in the Golden Archive of the Mongolian National Public Radio. The research aims to examine how the narrator's perspective, music, and the semiotic use of sound enrich the meaning and influence the listener's psychology.

The study applies methodologies from adaptation theory, narratology, media theory, and semiotic analysis to compare and analyze the differences in narrative, storytelling, and artistic devices between the original text and its radio adaptation. The results reveal that the harmonious combination of music, sound effects, and narration in the radio adaptation deepens the original meaning, effectively conveys the atmosphere of events and characters' emotions, and stimulates the imagination and emotional engagement of the audience. Radio adaptations of literary works not only transmit the original texts but also recreate them, offering listeners new experiences and forms of artistic expression.

Keywords: *composition, narrator, music, semiotics*

Оршил

Урлагийн төрөл бүхэн өөрийн онцлогт тохирсон илэрхийлэх аргатай билээ. Тэр нь түүний хэл юм. Тэрхүү хэл нь уран зурагт өнгө дүрсээр, бүжигт хөдөлгөөнөөр, хөгжимд аялгуугаар илэрхийлэгддэг бол сонсох урлаг буюу радиод дуу хоолой (голос, voice), дуу чимээ (шум, sound effect), дуу хөгжим (музыка, music) зэргээр дамжуулан сонсогчдод сэтгэлийн таашаал өгдөг (Амарзаяа 2006, 88). Эдгээрийг радиогийн дүрслэлийн хэл гэж нэрлэдэг. Радио урлаг нь хүний нүдэнд харагддаггүй, гарт баригддаггүй нь түүний сул тал боловч, тэр дутагдлыг нөхөх олон арга хэрэглүүрийг ашигладаг. Түүний нэг нь дуу хөгжим юм. Дуу хөгжим нь хүний сэтгэл зүйд хамгийн хүчтэй нөлөөлдөг бөгөөд сэтгэлийн утсыг хөндөж, уран сайхны мэдрэмжийг гүнзгийрүүлэх онцгой чадвартай урлаг юм.

Монгол Улсад радио уран сайхны бүтээл, радио зохиомжийн судалгаа нь XX зууны хоёрдугаар хагасаас эхлэн судлаачид, мэргэжлийн радиогийн уран бүтээлчдийн бүтээлч ажлын хүрээнд анх яригдаж эхэлсэн. Радио зохиомжийн төрөл зүйлийг онолын хувьд тодорхойлох, уран сайхны онцлогийг судлах чиглэлээр Л.Амарзаяа (2006), Г.Болор (2016), Д.Батжаргал, Г.Мэндхүү (2015)

нарын бүтээлүүдэд радио жүжиг, радио зохиомжийн онцлог, бүтэц, дуу хөгжмийн хэрэглээний тухай анхны судалгаанууд тусгагдсан байдаг.

Гадаадын судалгаанд радио зохиомж болон радиогийн уран сайхны бүтээлийг медиа онол, семиотик шинжилгээний үүднээс судалсан олон бүтээл байдаг. Тухайлбал, германы судлаач Гётц Шмедес радио зохиомжид үг хэллэгийг орлох болон баяжуулах дохио, тэмдэгт системүүдийн үүргийг онолын түвшинд судалсан (Schmedes 2002). Мөн Их британийн эрдэмтэн хөгжмийн ритм, хэмнэл нь медиа уран бүтээлд хэрхэн утга илэрхийлдэг талаар дэлгэрэнгүй тайлбарласан байдаг (Tagg, Philip 2013). Дээрх судалгаанууд радио зохиомжийг медиа, хөгжим судлал, семиотикийн онолоор судлах арга зүйн суурийг бүрдүүлж байна.

Радиод дуу хөгжмийг дүрслэх хэрэглүүрийн зорилгоор ашигладаг. Радио уран зохиолд дуу хөгжим нь өгүүлэмжийг гүнзгийрүүлэх, дүрийн дотоод сэтгэл, уур амьсгал, үйл явдлын хэмнэл, урьдач нөхцөл зэрэг нарийн агуулгуудыг илэрхийлэх семиотик хэрэглүүрийн чухал үүргийг гүйцэтгэдэг. Иймд радио уран сайхан нь өгүүлэмж, утга санаа, сэтгэл зүйг акустик тэмдэгтүүдийн тусламжтайгаар илэрхийлдэг нийлмэл урлаг юм. Германы судлаач Гётц Шмедес утга агуулга нь зөвхөн үгээр бус, үгийг орлох болон баяжуулах чадвартай дохио, тэмдэгт системүүдээр илэрдэг хэмээн тэмдэглэсэн (Schmedes 2002). Энэ нь радиогийн орчинд үг хэллэгийг орлох дуу авиа, хөгжим, чимээ зэрэг акустик хэрэгслээр нөхөж чаддаг. Ингэснээр радио зохиомж нь үг, дуу хөгжим, дуу чимээ хэмээх хэрэглүүрээр өгүүлэмжийн орон зайг өргөтгөж, сонсогчийн сэтгэл зүйд хүчтэй нөлөөлдөг. Мөн хөгжим нь дангаараа утга илэрхийлж чаддаг. Аль ч улс орны дуу хөгжим, үйл явдал, түүх домгийг өгүүлдэг учраас дуун найруулгад баатрын дотоод сэтгэлийн илэрхийлэл болгон хөгжмийг ашиглах нь шилдэг сонголт болдог (Болор 2018, 53). Монголын Үндэсний олон нийтийн радиогийн “Алтан сан хөмрөг”-т хадгалагдаж буй радио зохиомжууд нь хүүрнэл зохиолыг сонсох урлагийн хэлбэрт хөрвүүлэн, дахин бүтээсэн уран сайхны хувилбар юм. Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн”, “Шувуун саарал”, “Хуучин хүү”, “Соёлыг гайхав”, “Адууны манаанд”, “Үзэгдээгүй юм”, “Ламбугайн нулимс”, “Цагаан сар ба хар нулимс” зэрэг нийт 8 өгүүллэгийг радиод зохицуулан зохиомжилж, радио уран сайхны бүтээл хийж, радиогийн алтан сан хөмрөгт хадгалсан байна. Энэхүү өгүүллэд Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгээр хийсэн радио зохиомжийг шинжлэн судалж, радио бүтээл бүтэх үйл явц болон хөгжим, дуу чимээний семиотик утгыг тодруулахыг зорилоо.

“Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэг нь монголын уран зохиолын сор бүтээлүүдийн нэг бөгөөд байгалийн үзэсгэлэн, хүний сэтгэл хөдлөлийг нарийн дүрслэн харуулсан зохиол юм. Тус өгүүллэг нь уран дүрслэлээр баян, уянгын өнгө аяс нэвт шингэсэн, зохиолчийн өндөр мэдрэмжээр сонгогдсон үг, хэллэг, нүдэнд харагдахуйц амьд сонирхолтой дүр, дүрслэл, сэтгэл хөдөлгөөм, хүний сэтгэл зүйд нөлөөлөхүйц уран яруу найруулгын өнгө аяс, өнгө төрхийг тэр чигээр нь буулгасан зохиол юм. Зохиолч Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгт гол дүрийн амьдралд тохиолдсон нэгэн дан хэрэг явдлыг өгүүлэх бөгөөд хөдөөгийн хөхүүн цэнгэл, хүлэг морины хийморь, залуу бүсгүйн эрүүл биеийн гоо үзэсгэлэнг бахадсан нэгэн залуу эрийн бодлыг үзүүлнэ (Нандинбилиг 2018).

“Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгээр хийсэн радио зохиомжийг 1970 онд радиогийн нэрт нэвтрүүлэгч Монгол Улсын Соёлын гавьяат зүтгэлтэн С.Гунгаа уран уншиж, радиогийн алтан сан хөмрөгт хадгалсан байна. Монгол Улсын Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Э.Чойдогийн “Монголын сайхан орон” хөгжмийн найруулгаар “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгээр хийсэн хөгжимт радио зохиомжийг бүтээжээ. “Хөдөө талын үзэсгэлэн” хөгжимт радио зохиомж нь зохиолын үйл явдлын дүр дүрслэлийг улам тодотгож, утга санааг нэмэн дэлгэрүүлж, үйл явдлыг сонсогчийн нүдэнд харагдаж, чихэнд сонсогдохуйц байдлаар урласан нь радио уран сайхны онцлогийг илтгэн харуулж байна.

Монгол Улсын Төрийн шагналт хөгжмийн зохиолч Э.Чойдогийн бүтээлүүд нь монгол ардын аялгуу, уянгын хэмнэл, үндэсний хөгжмийн өнгө төрхийг өрнийн сонгодог хөгжмийн найруулгын арга барилтай чадварлагаар хослуулсан онцлогтой. Түүний хөгжмийн хэл нь монгол хүний сэтгэл зүй, үндэстний бахархал, байгаль орчны гоо сайхныг хөгжимд буулгаж, үйл явдлын уур амьсгал, сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд чиглэсэн байдаг. Тухайлбал, “Монголын сайхан орон” аялгуу нь монгол орны байгаль, ард түмний сэтгэл зүй, үндэстний бахархлыг хөгжимд уянгын хэлээр дүрсэлж, кино урлаг, радио уран сайхны бүтээлд үйл явдлын хэмнэл, сэтгэл хөдлөлийг илэрхийлэх чухал хэрэгсэл болсон байна.

Судалгааны арга зүй

Харьцуулсан шинжилгээ. Эх зохиол (Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн”) болон радио зохиомжийн бүтцийн харьцуулалтыг хийж, үйл явдал, өгүүлэгчийн байр суурь, дүрслэл, уран сайхны хэл найруулгын хувиргалын үйл явцыг тодорхойлов. Үүнд, текстийн хэлбэр, өгүүлэгчийн өнцөг, хүүрнэл дэх дотоод үзэл бодол хэрхэн өөрчлөгдөж буйг шинжилсэн.

Семиотик шинжилгээ. Радио зохиомж дахь дуу, хөгжим, авиа чимээг утга агуулгыг баяжуулах, уран сайхны санааг илэрхийлэх дохио тэмдэгт системийн хувьд тайлбарласан. Үүнд, хөгжмийн ритм, аялгуу, дуу чимээний сонсголын дүрслэлийн үүргийг семиотик тэмдэг зүйн талаас судалсан.

Медиа орчны шинжилгээ. Радио зохиомжийн бүтэц, илэрхийллийн хэлбэрийг радиогийн медиа орчны техник, технологийн онцлогтой уялдуулан тайлбарлаж, радио зохиомжийн акустик орон зай, сонсголын илэрхийлэл болж буйг судалсан.

Судалгааны үр дүн

Монголын шинэ үеийн уран зохиолыг үндэслэгч их зохиолч Д.Нацагдоржийн өгүүллэгүүд нь сэтгэл хөдлөлийн энгийн атлаа уянгалаг өнгө аястай тул радиод зохиомжлохдоо зөвхөн хөгжмийн найруулгаар зохиомжилсон нь сонсогчдын төсөөллийг улам нэмэгдүүлж байна. “Хөдөө талын үзэсгэлэн” радио зохиомжид дөрвөн төрлийн хөгжмийн ая, аялгууг дэвсэж, өгүүлэмжийн гадаад орчин, уур амьсгал, дүр төрхийг тодотгож, нэвтрүүлэгчийн хүүрнэн өгүүлэх өгүүлэмжийг хослуулан хөгжимт радио зохиомжийг хийжээ. Мөн хүүрнэн өгүүлэх өгүүлэгчийн хүүрнэл нь нэвтрүүлэгчийн дуу хоолойгоор дамжин сонсогчдод хүрэх нь зохиолын үйл явдлыг илүү тод томруун, ойлгомжтой болгохын зэрэгцээ сонсогчдод илүү дотно мэдрэмж төрүүлэх, өгүүлэгчийн үзэл бодол, мэдрэмжийг гүн гүнзгий мэдрэх боломжийг олгож байна.

“Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгээр хийсэн радио зохиомжийн онцлог

1. Эхлэл хэсэг: (ХӨГЖИМ) Хөгжмийн зохиолч Э.Чойдог “Монголын сайхан орон” баримтат киноны хөгжмийн аялгуу

НЭВТ: Хөдөө талын зэрэглээ мяралзан жирвэгнэхийн дунд хэдэн өндөр юм сүүмэлзэн үзэгдэх нь харь газрын аяны хүний нүдэнд яахин даруй танигдана. Хурдлан довтлох уурын тэрэгний өмнөөс намрын салхи хүчтэй үлээхэд хоёр нүдэнд нулимс гялтганан холын барааг харж ядна (Нацагдорж 1961). Радио зохиомжийн эхлэл хэсэгт алдарт хөгжмийн зохиолч Э.Чойдогийн “Монголын сайхан орон” баримтат киноны хөгжмийн аялгууг эгшиглүүлсэн нь Монгол орны бүх гоо үзэсгэлэн бүгд дүрслэгдэж, монголын тухай уран өгүүлэмж, уянгат хөгжим болон сонсогдож байна. Хүүрнэн өгүүлэгч өгүүллэгийг урнаар уншиж, хөгжим чимэглэлээр шигтгэж өгсөн нь уг өгүүллэгийн уран тансаг өгүүлэмжийг улам тодотгожээ.

Хүүрнэн өгүүлэгчийн ярианы хэмнэл, өнгө аясыг дуу чимээ, хөгжимтэй нягт улдуулан илэрхийлэх нь сонсогчдыг татаж, чих тавин сонсоход хүргэдэг билээ. Иймд сонсогчдыг үнэмшүүлж байж сэтгэлийг нь хөдөлгөнө, сэтгэлд нь хүрч байж урлагийн нөлөөлөх чадал биеллээ олно. Байгалийн зураглал, хүний сэтгэлийн нарийн мэдрэмжийг илтгэх зорилгоор хөгжмийн аялгууг ашигладаг. Ийм аялгуу болж байгаа үйл явдал, илэрхийлэх гэж байгаа зүйлийн утга агуулгад яв цав нийцэж байх учиртай. Хөгжмийн хэлээр зохиол дахь хэрэг явдал, баатрын сэтгэл зүйн байдал, зан төрхийн хувирал, уур амьсгал, орчин нөхцөл, байгалийн зураглал зэрэг бүхий л зүйлийг тодотгож, хүүрнэн өгүүлдэг онцлогтой.

1. Хөгжмийн ритмтэй ая

НЭВТ: Өвгөн жолооч ухасхийх, хийг нэмэхэд дөрвөн хурд чөлөө завгүй эргэлдэнэ.

Хөгжмийн ритмтэй ая нь радио зохиомжид үйл явдлын хөдөлгөөн, динамик байдлыг илэрхийлэх чухал үүрэг гүйцэтгэдэг. Хөгжим судлалын үүднээс ритм гэдэг нь хугацааны тасралтгүй урсгалд хэмнэл, цохилгын давтамж, акцентын зохицолдоон бүхий хөгжмийн элемент бөгөөд хүний сэтгэл зүйд хөдөлгөөн, динамикийг мэдрүүлдэг онцлогтой байдаг (Tagg, Philip 2013, 198). Радио зохиомжид машинтай давхиж буй дүрүүдийн хурд, орчны хөдөлгөөн, уур амьсгалыг дүрслэхдээ дунд темптэй, тогтмол хэмнэлтэй, цохилгоор хөдөлгөөнийг илэрхийлсэн ритмтэй хөгжмийн аяыг ашигласнаар техникийн хөдөлгөөн, байгалийн орчныг нэгдмэл уран сайхны дүрслэл болгон хувиргаж байна. Ийнхүү ритмтэй ая нь зөвхөн чимэглэл бус, үйл явдлын эрч хүч, сэтгэл хөдлөлийг сонсголын орон зайд амилуулах хөгжмийн семиотик хэрэгсэл болж байна.

2. Бүрээ, бишгүүр, цамын дуу чимээ

НЭВТ:...Бүртэлзэн харагдагч бараа нэг үе далд орж, нэг үе ил гарна. Удалгүй ойртон үзвээс өмнөх гүвээн дээгүүр сүм хийдийн орой бүртэлзэн цухуйж, алтан ганжрууд нь өглөөний нарны гэрэлд үзэсгэлэнтэй гялалзана. Тэрхүү хийдийн суварга тагт гайхамшигтай манжлага цамхагт өлгөсөн хонхны дуун нь хангинан жингэнэнэ. Бүрээ, бишгүүрийн дуу үргэлжлэн дүнгэнэнэ. Цам, жахар бүжиглэж байгаа юм байжээ. Хөдөөгийн хүмүүс хэд хэдэн зуугаар хуралдаад, эрээн мярааныг өмсөж, ийш тийш зөрөлдөнө. Энд хийдийн орчин, харагдах байдлыг дүрсэлсэн

бөгөөд бүрээ, бишгүүрийн дуу, хонхны жингэнэх чимээ зэрэг дуу чимээ, ая аялгууг үе шаттайгаар нэмэгдүүлэн ашигласнаар, сонсогчийг хийдийн орчинд орон зай, сэтгэл хөдлөлийн хувьд аваачиж байна.

Дуу чимээний найруулга нь зохиолын утга санааг зөвхөн үгээр бус, сонсголын дүрслэлээр дамжуулан мэдрүүлэх үүргийг гүйцэтгэж байна. Ийнхүү радио зохиомжид дуу авиа нь хүрээлэн буй орчин, утга агуулгын өгүүлэмжийг бий болгох бие даасан уран сайхны хэрэглүүр болж, хийдийн орчин, сүр жавхлант байдлыг зөвхөн үгээр биш дуу чимээний найруулгаар утгыг бий болгосныг ажиглаж болно.

3. Морин хуурын ая

НЭВТ:... Ийшээ ширтэж, тийшээ гэлрөн, үүнийг гайхаж, түүнийг бодсоор явтал, олон морьтой хүмүүсийн дундуур нэгэн сайхан саарал морины толгой тэмүүлэн ам нь ангалзаж, хоёр чих нь солбилзон үзэгдэхэд хэдийн миний хоёр нүд гэрэлтэн тусав. Нэг залуу хүүхэн жолоог дугтран зүтгүүлсээр гарч ирэх нь зэрлэг бугын адил өнгөтэй ба цог заль гэрэлтэй, жавхлантай нь түмэн баатар эрсийн боловч зүрхийг чичрүүлэн догдлуулж, төв эрдэмтэн оюутны боловч хүслийг холбилзуулан татна. Энэ хэсгийн радио хувиргалд дуу чимээ, өгүүлэгчийн хоолойн өнгө, хөгжмийг зөв найруулснаар эх зохиолд буй сэтгэл хөдлөл, үндэстний бахархал, гоо сайхны мэдрэмжийг сонсогчдод өгч байна. Радио зохиомжид энэхүү хэсгийг дүрслэн дамжуулахад өгүүлэгчийн дуу хоолойн хүүрнэл, дуу чимээний нарийн найруулга, сэтгэл хөдлөлийг дэмжих хөгжим зэрэг элементүүд чухал үүрэг гүйцэтгэдэг.

НЭВТ:... Сүлжилдэн давхилдах хөдөөгийн хүмүүсийн цэнгэл нь миний сэтгэлийг даруй бахдуулж, Сан бэйсийн морины сайхан нь миний дурыг хөвөлзүүлэн хөдөлгөнө. Монгол газар минь уужим юмаа. Мааш сайхан морьтой юмаа, морио унаад давхихад манай цог заль сэргэнэ. Энэ хэсгийн “Монгол газар минь уужим юмаа... цог заль сэргэнэ” гэх хэсэгт хөгжим нь дотоод сэтгэлийн уянгын аялгууг нэмэгдүүлсэн нь үндэстний бахархал, монгол хүний дотоод мэдрэмж, сэтгэл зүйг илэрхийлсэн хүчтэй акустик дүрслэл болсон. Ийнхүү хөгжим нь радио зохиомжид сэтгэл зүйн илэрхийллийн үндсэн хэрэгсэл болж, утга санааг улам тодотгож, сонсогчийн төсөөлөл, сэтгэлийг хөтлөх хүчтэй акустик дүрслэлийг бүтээж байна.

Д.Нацагдоржийн уянгын өгүүллэгүүд нь уран яруу дүр, дүрслэлтэй, уран зохиолын дүрслэх яруу хэрэглүүрийн бүхий л боломжуудыг ашиглан, уран зураг лугаа дүрсэлсэн тул зохиолын өгүүлэмжийг өөрчлөх боломжгүй бөгөөд радиогийн дүрслэлийн хэрэглүүр болох хөгжим, дуу чимээгээр утгыг дэмжих байдлаар зохиомжилсон нь сонсогчдын сэтгэл зүйд нөлөөлөх нөлөөг нэмэгдүүлж байна. Аливаа утга санааг тодруулсан хөгжим, ая, аялгуу, дуу чимээг өгч, өгүүлэгч буюу нэвтрүүлэгч уран тод, утгажуулан уншсанаар сонсогчдод илүү бодит төсөөлөл төрүүлдэг.

Өгүүллийн дараагийн хэсэгт хүүрнэн өгүүлэгчийн байр суурийг харьцуулан авч үзвэл, зохиолд өгүүлэгч нэгдүгээр биеэс эсвэл өгүүлэгч өөрөө тухайн зохиолын нэг баатар мэтээр хэрэг явдлыг өгүүлдэг бол зарим тохиолдолд хоёрдугаар биеэс буюу хөндлөнгөөс харж буй хүн, бүр “хэн болох нь мэдэгдэхгүй” өгүүлэгчийн үүргээр оролцдог (Галбаатар 2012, 275). Өгүүллэгт зохиолчийн дуу хоолой, “би” баатрын дуу хоолой давхцах ба өгүүлэгч “би” баатрын дуу хоолой нэгдүгээр биеэс

өгүүлж байна. Жишээ нь,

- Хурдлан довтлох уурын тэрэгний өмнөөс намрын салхи хүчтэй үлээхэд *хоёр нүднээ* нулимс гялтганан холын барааг харж ядна.
- Сүлжилдэн давхилдах хөдөөгийн хүмүүсийн цэнгэл нь *миний сэтгэлийг* даруй бахдуулж, Сан бэйсийн морины сайхан нь *миний дурыг* хөвсөлзүүлэн хөдөлгөнө.
- Ийшээ ширтэж, тийшээ гөлрөн, үүнийг гайхаж, түүнийг бодсоор явтал, олон морьтой хүмүүсийн дундуур нэгэн сайхан саарал морины толгой тэмүүлэн ам нь ангалзаж, хоёр чих нь солбилзон үзэгдэхэд хэдийн *миний хоёр нүд* гэрэлтэн тусав.
- Харах нүдний хар цагаан нь хослоод хотын залуу хүний дээр эелдгээр хөдлөх тутам *миний нүд* эрхгүй дагалдан давхина.
- Хэрэв *би* морьтой болоод завтай явсансан бол доо.

Радио зохиомжийн өгүүлэгчийн хүүрнэл, байр суурь:

...*Ташаа нь тэвхийж, хавирганы яс нь зурайсан ялгуун саарал морь нь тогтоож ядан, гуа сайхан дөрвөн хөлөөрөө ээлжлэн газар цавчилж, уран сайхан толгойгоо ийм тийш сэжих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдах боловч дээр нь унасан үзэсгэлэнт охин ажиггүй сууж үгүүлэлдэх бөгөөд үг хэлэлцэн хичээнгүйлэн ааших нь бага хүүхэд мэт хөнгөмсөг ээвэрүү, хасын өнгөтэй дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан үе үе инээмсэглэн мишээхэд нь үнсэж шимбэл ханашгүй биз ээ. Энэ хэсэгт эрэгтэй хүний дотоод мэдрэмжийг нэгдүгээр биеийн хүүрнэлээр дамжуулан, байгалийн гоо сайхан болон хүний дотоод сэтгэлийн хөдөлгөөн хэрхэн уялдан нэгэн цогц уран сайхны ертөнц болж буйг харуулдаг. Энэ нь Д.Нацагдоржийн монгол ахуй, уламжлал, гоо зүй, хүний сэтгэл зүйг нэгэн дор шингээж өгсөн уран сайхны өндөр түвшний дүрслэл болж чаджээ.*

“...*Хээр талын дунд хөндлөн гулд давхиж, хөдөөгийн саруулд биеэ гайхуулсан ийм нэг үзэсгэлэнт охинтой учраад, хэрхэн сэтгэл хөдлөхгүй байж болох ажээ.*” “...*Хоолойн товчийг задгай тавьсны дотуур бас хар торгоор бөөрөнхийлөн эмжсэн цайвар шар дурдан цамцны зах цухуйж, түүний дотор нимгэн цагаан хөрстэй гуа хүзүү үзэгдэхэд хазаад авмаар...*” гэсэн өгүүлэмжүүдээс харахад зохиолын өгүүлэгч нь эрэгтэй хүн бөгөөд үйл явдлыг хөтлөх дүр байдлаар оролцож байна. Өгүүлэгчийг уран зохиолын онолд зохиолын үйл явдлыг хөтлөгч, өвөрмөц маягийн дүр гэж ойлгоно. Тэр нь зохиолын баатруудад хэрхэн хандаж, юу гэж бодож, сэтгэж байгааг илрүүлэн гаргадаг нэгэн төрлийн уран дүр, дүрслэх арга болдог (Галбаатар 2012, 277).

“...*Хэрэв би морьтой болоод завтай явсансан бол доо.*” Энэ өгүүлэмжээс харахад өгүүлэгч нь тухайн үйл явдалд оролцогч нэгэн мэтээр нэгдүгээр биеийн хүүрнэлээр дамжуулан өөрийн сэтгэл хөдлөл, хүсэл тэмүүллийг илэрхийлж байна. Энэ нь уншигчийг өгүүлэгчийн дотоод ертөнцөд шууд хөтлөн оруулж, зохиолын утга агуулгатай гүн холбогдох боломжоор хангадаг. Харин радио зохиомжид хүүрнэн өгүүлэгч нь нэвтрүүлэгчийн дуу хоолойгоор илрэх ба энэ хэсгийг нэгдүгээр биеийн өгүүлэмжээр өгүүлж байгаа нь эх зохиолд буй хүүрнэлтэй ижил байна. Уран зохиолд өгүүлэгч зохиол дахь уран дүрийн хэл ярианаас ялгарах өөрийн өвөрмөц хэл найруулгатай. Тэр нь өөртөө тухайн зохиолын бусад баатруудын хэл

яриаг багтааж, зохиолын хэлний бусад бүхий л хэлбэршлүүдийг нэгтгэснээрээ онцлог юм. Харин радио зохиомжид хүүрнэн өгүүлэгч буюу нэвтрүүлэгчийн дуу хоолой нь сонсогчид шууд хүрч, түүнийг дүрийн сэтгэл хөдлөл, зохиолын утгатай илүү ойр холбодог. Ийнхүү радио хувиргалд хүүрнэн өгүүлэгчийн байр суурь нь зөвхөн зохиолын хэрэг явдлыг дамжуулагч төдий бус, харин сонсогчийн төсөөлөл, сэтгэл хөдлөлийг хөтлөх хүчтэй дуу хоолойн дүр болон хувирч байна.

Хэлэлцүүлэг

Хөгжмийн семиотик шинжилгээний үр дүнд радио зохиомжид хөгжим, дуу чимээ нь дан ганц чимэглэл бус уран сайхны утга дамжуулагч тэмдэг зүйн систем болж буйг тогтоов. Морин хуурын ая нь баатрын дотоод сэтгэлийн хөдөлгөөн, үндэстний бахархлыг илэрхийлж, сонсогчийн төсөөлөлд дүрийн сэтгэл хөдлөлийг амилуулан, үйл явдлын уур амьсгалыг гүнзгийрүүлж өгсөн нь онцлог үр дүн байлаа. Мөн машины дуутай хослуулсан ритмтэй хөгжим нь үйл явдлын хэмнэл, динамикийг илэрхийлэх семиотик тэмдэг болж, сонсголын орчинд үйл явдлын хөдөлгөөнийг мэдрүүлэх үүргийг гүйцэтгэсэн байна. Радио зохиомжид дуу чимээ, хөгжим нь үгийн өгүүлэмжээс гадна акустик тэмдэгт хэлбэрээр үйл явдлын уур амьсгал, дүрийн зан төлөв, сэтгэл зүйн байдлыг илэрхийлж, уран сайхны илэрхийлэлд давхар утга үүрэг гүйцэтгэсэн нь семиотик үүднээс онцгой үр дүн болж байна. Ийнхүү радио зохиомж нь акустик тэмдэгт системийг бүтэцчилсэн уран сайхны хэлбэр болж, эх зохиолын утгыг медиа орчны онцлогт нийцүүлэн дахин бүтээсэн нь энэхүү судалгааны чухал дүгнэлт юм.

Дүгнэлт

Их зохиолч Д.Нацагдоржийн “Хөдөө талын үзэсгэлэн” өгүүллэгийн радио хувиргал нь бичгийн хүүрнэл дүрслэлийг сонсголд зориулсан уран сайхны хэлбэр юм. Радио зохиомжид хөгжим, дуу чимээ, хүүрнэл гурвын зохистой хослол нь зохиолын утга агуулгыг улам гүнзгийрүүлж, сонсогчийн төсөөлөл, сэтгэл хөдлөлийг өдөөхөд гол үүрэг гүйцэтгэж байна. Хөгжим, дуу чимээ нь зөвхөн чимэглэл бус уран сайхны санааг илэрхийлэх, үйл явдлын уур амьсгал, дүрийн сэтгэл зүйг тодотгох бие даасан акустик тэмдэгт систем болон үйлчилж байна. Ийнхүү уран зохиолын радио хувиргал нь эх зохиолыг дамжуулахаас гадна түүнийг медиа орчны онцлогт нийцүүлэн дахин бүтээж, сонсогчдод шинэ уран сайхны илэрхийлэл, мэдрэмжийг бүрэлдүүлэх өвөрмөц уран сайхны хэлбэр болсныг энэхүү судалгаа баталж байна.

Ашигласан номын жагсаалт

Монгол хэлээр:

Амарзаяа, Л. 2006. *Радио жүжиг*. Улаанбаатар: Жиком.

Болор Г. 2018. *Дууны найруулга*. Улаанбаатар.

Галбаатар, Д. 2012. *Уран зохиолын нэвтэрхий толь. Онол, түүх, шүүмж*. Улаанбаатар.

Нандинбилиг, Г. 2018. *Хүүрнэл зохиолыг задлан шинжилж, заан сургахуй*. Улаанбаатар.

Нацагдорж, Д. 1961. *Түүвэр зохиол*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.

Гадаад хэлээр:

Schmedes, G. 2002. *Medientext Hörspiel. Ansätze einer Hörspielsemiotik*.

Tagg, Philip. 2013. *Music's Meanings: A Modern Musicology for Non-Musos*. New York: The Mass Media Music Scholars' Press.

Архивын материал:

“Алтан сан” хөмрөгийн “Уран зохиол” дуу авианы бүртгэл (1955–2012). МҮОНР.

Алтан сангийн дуу бичлэгийн архив. 2012. Монголын Үндэсний олон нийтийн радио. Монголын Үндэсний олон нийтийн радио.